

**СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин буюу хүрсэн түвшин, хэрэгжилт	Арга хэмж ээний тоо	Гүйцэт гэлийн хувь
ЗОРИЛГО: ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХУЙЦ, ЧАНАРТАЙ АЮУЛГҮЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛНЭ.							
Зорилт 1: Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ.						3	100
Зорилт 2: оношилгоо, эмчилгээ, үйлчилгээний дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх нутагшуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй, эрсдэлгүй ээлтэй орчин бүрдүүлэх						16	57,5
Зорилт 3: Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, нийгэм хамт олны оролцоог нэмэгдүүлэн, сэтгэцийн эрүүл мэндээ хянаж сайжруулах талаар хувь хүн, хамт олны мэдлэг, чадварыг дээшлүүлэх						16	91,9
Зорилт:4: Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлс, зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тандалтыг сайжруулна						8	80
Зорилт 5: Хүний нөөцийн хөгжлийг дэмжих, ажилтнуудын ёс зүйг сайжруулах, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан цалин урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх						3	93,3
Зорилт 6: Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах						5	92
Зорилт 7: Гамшгийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллах, шинэ болон сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх						3	96,6
ХЭРЭГЖИЛТИЙН НИЙТ ХУВЬ						54	87,3

ЗОРИЛТ 1: Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ.							
1.1	Хүн ам дунд сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулах /БСТ 1.1.2/	100.0 (ДЭМБ)	Үзлэг зохион байгуулсан тоо	Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх сэтгэцийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд 93,846 хүн	Сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулж үр дүнг тооцно: Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт нийт 12,370 иргэн хамрагдаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан байна.	100%	

				хамрагдсан.		
1.2	Аутизмын хүрээний эмгэгийг илрүүлэх, ADOS-2 үнэлгээ оношилгооны шинэ аргыг нэвтрүүлэх /БСТ 2.2.5/	150.0 (Үйл ажиллаг ааны орлого)	Сургалтад хамрагдсан эмчийн тоо	ADOS-2” буюу аутизмын оношилгоо, үнэлгээний аргын 5 модуль гарын авлагыг Монгол хэлнээ орчуулж үйл ажиллагаандаа хэрэглэхэд бэлэн болгосон.	Эрүүл мэндийн сайдын дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн санхүүжилтээр Монгол улсад аутизмын хүрээний эмгэгийн үнэлгээ оношилгооны шинэ аргыг нэвтрүүлэх төслийн дагуу хүүхдийн сэтгэцийн эмч нар Бүгд Найрамдах Турк Улсын Трабзон хот дахь Кануни Их сургуулийн эмнэлгийн Хүүхэд өсвөр үеийн сэтгэцийн эмгэг судлалын тасагт Аутизмын оношилгоо, үнэлгээний “ADOS-2” аргачлалын онол болон дадлага сургалтанд хамрагдсан. 2025 оны 4-р сараас эхлээд шинжилгээний өрөөг тохижуулж одоогийн байдлаар 275 хүүхэд Аутизмын оношилгоо үнэлгээний “ADOS-2” үнэлгээ хийсэн байна. Үүнээс Аутизм-185 хүүхэд, аутизмын хүрээний эмгэг – 56 хүүхэд, аутизмын хүрээний биш эмгэг-34 хүүхдэд оношлогдсон байна. Хүүхдэд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Монголын Сэтгэцийн Эрүүл Мэндийн Нийгэмлэг хамтран “ADOS-2” аутизмын оношилгоо, үнэлгээний арга зүйн хоёр дах сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтыг Бүгд Найрамдах Турк Улсын сэтгэцийн эмч, профессор Онур Бурак Дурсун удирдан, аргазүйгээр хангасан. Аутизмыг (ADOS-2) олон улсын оношилгооны стандартчилсан арга зүйгээр оношилж, оношлоход зориулагдсан тоглоом, ярилцлагын арга зүй, хүүхдийг 12 сартайгаас хойш ажиглах арга зүйг бэлтгэх, үнэлгээ хийх арга зүйг оролцогчид эзэмшсэн. Сэтгэцийн эмч, сэтгэлзүйч, хүүхдийн сэтгэцийн эмч нараас бүрдсэн нийт 15 хүн оролцсон.	100%

						
1.3	“Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, холбогдох газарт хүргүүлэх	-	“Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар батлуулсан байна.	“Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бэлтгэл ажил хангагдсан.	Эрүүл Мэндийн Сайдын 2025 оны 1-р сарын 29-ны өдрийн А/24 тоот тушаалаар “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” хуулийн хэрэгжилтэнд үр дагаварт үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулагдсан. Хууль зүйн хүрээлэнгийн судлаачидтай хамтран: Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний судалгаа Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцооны судалгаа Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ хийх чиглэлээр судалгаа хийгдэж дээд шатны байгууллагад хүргэгдсэн.	100%
Зорилт 2: Оношилгоо, эмчилгээ, үйлчилгээний дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх нутагшуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй, эрсдэлгүй ээлтэй орчин бүрдүүлэх						
2.1	Тоон тархины цахилгаан бичлэгийн аппаратыг практикт	50.0	Шинээр оруулж ирсэн төхөөрөмж Оношилгоонд хамрагдсан	Манай улсад хэрэглэж байгаагүй.	Дээрх тоног төхөөрөмжийг эмчилгээнд нэвтрүүлэх судалгааны ажил хийгдэж саналаа хүргүүлсэн боловч 50.000.000 сая төгрөгийн төсөвт суугаагүй тул авалт хийх боломжгүй болсон.	0%

	нэвтрүүлэх		үйлчлүүлэгчийн тоо			
2.2	Гавлын хөндийн соронзон өдөөлт (Транскарниал магнетик стимуляци) эмчилгээ нэвтрүүлэх	150.0	Шинээр оруулж ирсэн төхөөрөмж	Манай улсад хэрэглэж байгаагүй.	Дээрх тоног төхөөрөмжийг эмчилгээнд нэвтрүүлэх судалгааны ажил хийгдэж саналаа хүргүүлсэн боловч 150.000.000 сая төгрөгийн төсөвт суугаагүй тул авалт хийх боломжгүй болсон	0%
2.3	Хиймэл оюун ухаанд суурилсан дижитал рентген аппаратыг практикт нэвтрүүлэх	-	Үйлчлүүлсэн хүний тоо	Оношилгоонд хэрэглэж байгаагүй.	Тус төвд хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгч болон Сэтгэцийн урт хугацааны эмгэг /F99/-тэй, сүрьеэ өвчнөөр өвчилсөн эмлүүлэгчдэд чанартай, хүртээмжтэй эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор идэвхитэй илрүүлэг үзлэгийг жил бүр Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулдаг бөгөөд 2023 онд тус төвийн эмчлүүлэгчдийн дунд сүрьеэ өвчний дэгдэлт гарч “Сүрьеэгийн дэгдэлтийг тандах, хянах, хариу арга хэмжээг зохион байгуулах” ажлыг тогтмол хийх шаардлага үүссэн. Идэвхитэй үзлэгт шаардлагатай байсан хиймэл оюун ухаанд суурилсан 93.020.000 төгрөгийн өртөг бүхий зөөврийн рентген аппарат PXM-40BT иж бүрдлийн хамт 2024 оны 12 сарын 26 өдөр Эрүүл мэндийн яамнаас хүлээн авч 2025 онд тусламж үйлчилгээнд нэвтрүүлж нийт 968 хүнд шинжилгээ хийснээс 68 эмчлүүлэгч, уушгины сүүдэржилт 60 хувиас дээш байсан тул 23 хүнийг цэрний шинжилгээнд илгээсэн байна.	100%
2.4	Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээг өргөжүүлэн, үйл ажиллагааг тогтмолжуулах /БСТ 2.2.3/	-	Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээнд хамрагдсан хүний тоо	Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээ болон клиникийн уялдааг сайжруулах шаардлага	Архинд донтох эмгэгтэй хүмүүсийн сэтгэц нийгмийн сэргээн засах төвүүдийг Нийслэлийн дүүргүүдэд шинээр нээх талаар дүүргүүдийн Засаг даргын тамгын газар, эрүүл мэндийн төвтэй хамтран, 9 дүүргийн 300 хорооны дарга, өрхийн эмнэлгийн дарга, нийгмийн ажилтан, хэсгийн цагдаа нарыг хамруулсан 7 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Сэтгэцийн сэргээн засах тусламж үйлчилгээг өргөтгөн ажиллахаар төвийн шинэчлэн батлуулсан бүтэц дүрэмд	30%

				байгаа	оруулан ирэх жилд бие даасан байдлаар ажиллуулахаар бэлтгэл ажил ханган ажиллаж байна. Сэтгэц, нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээний чиглэлээр: Дархан-Уул аймагт Хөдөлмөр халамжийн газрын дэргэдэх "Жаргалтай амьдрал" сэргээн засах төв үйл ажиллагаа явуулж байна. Өвөрхангай аймагт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа бүсийн албадан эмчилгээний төв нээгдсэн. Өмнөговь аймагт Засаг даргын тамгийн газрын харьяа "Итгэлтэй амьдрал" төрийн өмчит байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Баянхонгор аймагт "Жаргалтай амьдрал" нийгмийн сэргээн засах төв байгуулагдаж, ажиллаж байна. Хан-Уул дүүрэгт нийгэм сэтгэл зүйн сэргээн засах жишиг төвийг байгуулан ажиллаж байгаа ба давхардсан тоогоор нийт 7.905 архинд донтох эмгэгтэй хүнд тусламж үйлчилгээ үзүүлж, 283 хүн ганцаарчилсан зөвлөгөө, 3.064 хүнд бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө, 1492 хүнд бүлгийн сэдэлжүүлэх үйлчилгээ, 434 хүнд 12 алхамд суурилсан Миннесота донтох эмгэгийн сэтгэл заслын хөтөлбөрт, 606 хүн “АА” цуглаанд хамрагдсан байна. Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвд “Сэтгэц нийгмийн сэргээн засах төв” үйл ажиллагаа эхлэх бэлтгэл ажил явагдаж байна.	
--	--	--	--	--------	--	--

2.5	Донтох эмгэг судлалын клиникт хандлагаар эмчлэх сэтгэл заслын 2 арга шинээр нэвтрүүлж, үр дүнг тооцох /БСТ 1.2.1, 1.2.2/	-	Эмчилгээнд хамрагдсан хүний тоо	Уг эмчилгээ огт хийгдэж байгаагүй.	Архинд донтох эмгэг нь тухайн ганц хүний асуудал бус тухайн эмчлүүлэгчийг дагалдан гэр бүлийн бусад гишүүд бүгд давхар хамаарал өвчнөөр өвддөг тул гэр бүлийн насанд хүрэгдчдэд /эхнэр, нөхөр, аав, ээж гм/ “Давхар хамаарал” гэдэг ойлголтыг өгсөнөөрөө тухайн эмчлүүлэгчийн эдгэрэлтэнд тэдний дэмжлэг нөлөө, эдгэрэлтийн үр дүнгээ урт удаан хугацаагаар амжилттай батжуулж явахад гэр бүлийн хүмүүсийн оролцоо, дэмжлэг гэр бүлийн гишүүдийн донтох өвчний талаархи зөв ойлголт мэдлэгийг сайжруулах нь чухал үүрэгтэй тул 7 хоног бүрийн Лхагва гариг бүрт сэтгэл зүйч Ч.Энхчимэг “Давхар хамаарал” гэр бүлийн уулзалт ярилцлагыг зохион байгуулж хэвшсэн. Нийт 312 гэр бүлийн гишүүд хамрагдсан. Тайлант хугацаанд нийт 22 эмчлүүлэгчийг олон улсын “Коломбо хөтөлбөр”-ийн хөтөлбөрт сургалтад “Бэлэн байдлын хэмжүүр” сэдэлжүүлэх ярилцлагын аргыг нэвтрүүлсэн.	100%
2.6	Сэтгэл засал эмчилгээний тасгийг шинээр нээж өрөөнүүдийг засаж, тохижуулах	10.0	Засварлаж тохижуулсан өрөө	Өрөөний зарим хэсэг болон эд зүйлс элэгдэж хуучирсан.	2025 оны 04 дүгээр улиралд хийгдэхээр бэлтгэл ажил хангагдаж байна. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн бүтэц, үйл ажиллагааны дүрмийг шинэчлэн батлуулсан бөгөөд тус дүрэмд “Сэтгэл заслын тасаг”-ийг шинээр бие даасан байдлаар ажиллуулахаар батлуулсан. (Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 сарын 15-ний өдрийн “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” А/349 тоот тушаал) 2026 оны 01 сараас шинэчилсэн дүрмээр ажиллуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	60%
2.7	Сэтгэл засал эмчилгээний 2 аргыг нэвтрүүлж, үр дүнг тооцох /БСТ 2.2.2/	3.5	Эмчилгээнд хамрагдсан хүний тоо	Тус клиникт уг эмчилгээ хийгдэж байгаагүй.	Нийт 118 хүнд ганцаарчилсан сэтгэл заслын тусламж үзүүлсэн. Үүнд: - Ганцаарчилсан сэтгэлзүйн зөвлөгөө – 48 - Төрх үйлийн сэтгэл засал эмчилгээ – 12 - Танин мэдэхүйн сэтгэл засал эмчилгээ – 36	100%


				- Психоаналитик сэтгэл засал эмчилгээ-14 - Психодинамик сэтгэл засал эмчилгээ-8 Нийт 321 хүнд бүлгийн сэтгэл засал эмчилгээний тусламж үзүүлсэн. Үүнд: - “Аутотрейнинг” сэтгэл засал эмчилгээ-184 - Танин мэдэхүйн сургалт-69 - “Тайвшруулах иог”-42 - Урлагийн сэтгэл засал эмчилгээ-26 Шинээр нэвтрүүлсэн аргууд: - Тайвшруулах иог - Сbst энэрэх сэтгэлийн бясалгалын арга Төвийн эмч, мэргэжилтнүүдийн сэтгэл зүйн тэнцвэртэй байдлыг нэмэгдүүлэх, ажлын байрны стрессийг бууруулах, үйлчлүүлэгч болон хамт олонтойгоо харилцах энэрэнгүй харилцааг хөгжүүлж, мэргэжлийн түвшний ажлаас халшрах хам шинжээс сэргийлэх зорилгоор энэхүү сэтгэл заслын аргыг нэвтрүүлсэн. Энэхүү бясалгалын аргыг Америкийн Нэгдсэн Улсын Эмори их сургуулийн доктор, гэвш Лувсан Данзан Нэги-ийн боловсруулсан арга зүйгээр нийт дараах бүлэг сэдвүүдийн хүрээнд сургалтыг зохион байгуулсан. Үүнд: Сэтгэл төвлөрөл ба өөрийгөө таних: Анхаарал тогтворжуулах, дотоод сэтгэлээ шүүмжлэлгүйгээр ажиглах дадлага. Өөрийгөө энэрэхүй: Өөрийн эмзэг талыг хүлээн зөвшөөрч, өөртөө хайр халамжтай хандах арга техник. Бусдыг энэрэхүй: Бусдын зовлонг ойлгох, талархах сэтгэлийг төрүүлэх, харилцан хамааралтай гэдгээ ухамсарлах. Энэрэх сэтгэлийг бэхжүүлэх: Энэрэх сэтгэл дээр суурилсан зөв шийдвэр гаргалт ба идэвхтэй үйлдэл. Шинжлэх ухааны үндэслэлтэй танин мэдэхүйн дахин үнэлгээний аргууд. Шинжилсэн бясалгалын дадлагууд. Хэлэлцүүлэг болон өдөр тутмын амьдралд хэвшүүлэх дасгалууд.	
--	--	--	--	---	--

					Энэхүү СВСТ сэтгэл заслын арга техникийг сургах сургалтад 31 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж бэлтгэгдсэн бөгөөд эдгээр бэлтгэгдсэн эмч нар төвийн нийт клиник, тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан бясалгалын аргыг хэрэглэж байна.	
2.8	Кеттэлийн оюун ухааны хүчин зүйлийн аргачлалыг сэтгэл зүйн оношилгооны практикт нэвтрүүлэх /БСТ 2.2.2/	1,5	Оношилгоонд хамрагдсан хүний тоо	Уг аргыг огт хэрэглэж байгаагүй.	Кеттэлийн оюун ухааны хүчин зүйлийн аргачлал буюу оюун ухааны түвшин тогтоох /8-19 насныханд зориулагдсан/ аргачлалыг Орос хэлнээс эх хэлнээ орчуулаад дууссан, гарын авлагаа хянах шатандаа ажиллаж байна. Үүний дараа Оюун ухааны түвшин тогтоох Векслерийн сорилтой харьцуулсан судалгаа хийж тохироц чанарыг үзэхээр бэлдэж байна.	30%
2.9	Хүүхдийн апперцепцийн аргыг сэтгэл зүйн оношилгооны практикт нэвтрүүлэх	1,5	Оношилгоонд хамрагдсан хүний тоо	Уг аргыг огт хэрэглэж байгаагүй.	Хүүхдийн апперцепцийн аргыг сэтгэл зүйн оношилгооны аргачлалыг орчуулж бэлтгэл ажлыг хангаж байна.	30%
2.10	Шинэ туслах сувилагчийг чадавхжуулах “Туслах сувилагчийн сургалт” сэдэвт сургалтыг сар бүр зохион байгуулах /БСТ 2.1.2/	-	Сургалтад хамрагдсан тоо	Уг аргыг огт хэрэглэж байгаагүй.	Шавилан сургалтаар Дундговь аймгийн Г.Тувааны нэрэмжит нэгдсэн эмнэлгийн туслах сувилагч, Ч.Норовоог СЭМҮТ-ийн үйл ажиллагаа, сэтгэцийн эмгэгтэй хүнтэй харилцах харилцааны онцлог, сэтгэцийн байдалд ажиглалт хяналт тавих, эмнэлэг хамгааллын дэглэмийн тухай ойлголт, асаргаа сувилгааг хэрхэн үзүүлэх талаар дагалдуулан сургаж, тайлангийн хамгаалалт хийлгэн баталгаажуулсан. Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасгийн сувилагч Б.Мөнхзулыг “Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуй мэргэшүүлэх” түргэвчилсэн сургалтаар сургаж мэргэшүүлсэн. Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасгийн ахлах сувилагч Б.Анхзаяаг “Сэтгэц донтолтын мэргэшил дээшлүүлэх” сургалтаар 1 сарын хугацаатай дадлагажуулан	100%

					сургасан. Ерөнхий захирлын 2025 оны 10 дугаар сарын 12-ны А/304 дугаар тушаалын дагуу Анагаахийн шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургуулийн Суурь сувилахуйн тэнхимтэй хамтран ажлын байран дээр чадавхижуулах 60 туслах сувилагчийг 3 сарын сургалтад хамруулсан. Сувилахуйн алба сувилагч, туслах сувилагч нараас ерөнхий сувилахуйн болон сэтгэцийн сувилахуйн тусламж үйлчилгээг багтаасан 30 асуулт бүхий мэдлэг бататгах сорил, гардан үйлдлийн 11 тохиолдол тооцуулан шалгалт авсан. Шалгалтад нийт 16 клиник тасгийн сувилагч, туслах сувилагч нарыг хамруулсан . Онолын шалгалтад 70 сувилагч, гардан үйлдлийн шалгалтанд 48 сувилагч хамрагдсан бол туслах сувилагч онолын шалгалтанд 65, гардан үйлдлийн шалгалтанд 62 хүн хамрагдсан байна.	
2.11	“Амилуулах суурь тусламж” сэдэвт сургалт зохион байгуулах /БСТ 2.1.2/	-	Сургалтад хамрагдсан тоо	Уг аргыг огт хэрэглэж байгаагүй.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн нийт 68 ахлах сувилагч, сувилагч нарыг “Амилуулах суурь тусламж-тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа” чадавхжуулах сургалт, чанарын өдөрлөг зохион байгуулсан. Төрөлжсөн мэргэшлийн “Донтох эмгэгийн сувилахуй” төгсөлтийн дараах мэргэшил дээшлүүлэх аддиктологийн төвийн 6 сувилагчыг 1 сарын хугацаатай сургалтад	100%

					хамруулсан.	
2.12	Сувилахуйн зөвлөх багийг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулан хамтарч ажиллах	-	Хамтран ажиллаж зөвлөн, дэмжиж ажилласан тоо	-	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирлаар 2025 оны 1 дүгээр сарын 15-ний өдөр сувилахуйн “Зөвлөх баг”-ийн ахлагч, гишүүд, ажиллах хуваарийг батлуулсан 14 хоногт тойрон үзлэг хийн, үзлэгийн мөрөөр дүгнэлт гарган, зөвлөмж өгч ажилласан	100%
2.13	Донтох эмгэг болон сэтгэц, зан үйлийн эмгэгийг 10 эмнэл зүйн заавар батлуулах /БСТ 1.2.1/	2,0 (Үйл ажиллаг ааны орлого)	Батлуулсан заавар	Донтох эмгэгийн эмнэлзүйн заавар мөрдөж ажиллах	Донтох эмгэг болон сэтгэц, зан үйлийн эмгэгийн 11 зааврыг боловсруулж дууссан бөгөөд боловсруулсан зааврыг хянаад Сэтгэц судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Эрүүл Мэндийн Яаманд хүргүүлсэн.	70%
2.14	ГБХНХЯ-тай хамтран “Хүүхдэд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлага” стандартыг шинээр боловсруулж батлуулах	-	Батлуулсан стандарт	Хүүхдэд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх шаардлагад чиглэсэн батлагдсан стандарт байхгүй.	“Хүүхдэд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлага MNS7065:2025” стандартыг Стандарт хэмжилзүйн газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн “Үндэсний стандартыг шинээр болон шинэчлэн батлах, хүчингүй болгох тухай” С/6 дугаар тушаалаар Улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч, үндэсний стандартаар шинээр баталсан бөгөөд тус төв нь үйл ажиллагаандаа стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна.  MNS 7065:2025 Өмнөх үг Стандарт, хэмжил зүйн газар нь Олон Улсын стандартчлалын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд Улсын стандартчлалын бодлогыг төрийн болон төрийн бус байгууллагад хамтран хэрэгжүүлдэг. Тус газар нь тухайн салбарын үндэсний стандартын төсөл боловсруулах ажилг төлөөнийг хяналт, дэмжлэг үзүүлдэг. Төсвийн хэрэгсэл, хөрөнгийг зөвшөөрсний стандартын төсвийг Стандартчлалын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно. Энэ стандартыг Хүүхдэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дая хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3 дая хэсэг, 23 дугаар зүйлийн 23.9 дая хэсгийн хэрэгжлэгийг хангах зорилгоор Дэлгэрэнгүй мэдээллийг байгууллага, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүн амын сан зэрэг олон улсын байгууллагад боловсруулсан хүчирхийлэлийн хамрагч хуудас, үнэмлэх дэмжлэг, тусламж, үйлчилгээний үндэсний заавар болон Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай ба Хүүхдэд хамгааллын тухай хууль, тэдгээрийг дэлгэрэн гарсан дүгэм, журам, зааварт нийцүүлэн боловсруулсан. Энэ стандартыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэл, аюулгүй байдлын зогсоо дотроо Д.Орхонцогт, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хянан Гэр бүлийн бодлогын газрын хэрэгжлэгийг зохицуулах газрын Хүүхдийн эрхийн хууль тогтоомж, бодлого, төлөвлөлт хариуцсан шатнаар Ж.Амгарт, Монгол Улсын Боловсролын их сургууль, Боловсрол судлалын сургуулийн Нийгмийн ажил эрх ашгийн төлөөний албан хаагч Т.Булганова, зөвлөх, судлаач Ц.Булганова нар боловсруулсан. Энэ стандартыг Хүүхдийн өмжлөл, хамгааллын стандартчлалын төлөөний хэрэгсэл хурлаар хэлэлцж зөвшөөрсний болно. Стандарт, хэмжил зүйн газар Улаанбаатар хот 2025 он	100%

					үйлчилгээ шаардлагатай хүүхдүүдэд дээрхи стандартын хүрээнд тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан. Үүнээс: Амбулаториор тусламж авсан – 5970 Хэвтэн эмчлүүлсэн – 278 Сэтгэлзүйн тусламж үйлчилгээ авсан – 647 (дан тоогоор) Шүүхийн сэтгэцийн үзлэг хийгдсэн – 126 Төвийн хэмжээнд сэтгэл засал эмчилгээний 4 өрөө ажиллаж байгаагаас 1 өрөө нь бүлгийн эмчилгээний өрөө, 3 нь ганцаарчилсан сэтгэл засал эмчилгээний өрөө байна. Хүүхдийн сэтгэцийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа Хүүхэд өсвөр үеийн клиник нь нийт 5 эмчтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс: 2 эмч - амбулаторын хүүхдийн үзлэгийн кабинетэд, 2 эмч - Аутизмын оношилгоонд, 1 эмч - хэвтэн эмчлүүлж буй хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлдэг. Хүүхдийн үзлэг эмч нар бүгд Сэтгэл засалч эмчээр мэргэшиж бэлтгэгдсэн.	
2.15	Үндсэн болон төрөлжсөн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлт боловсруулах	-	Батлагдсан чанарын шалгуур үзүүлэлт	Тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлт төвийн захирлаар батлуулан дүн шинжилгээ хийж байгаа хэдий ч шинэчлэх шаардлагатай	Тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлт батлагдсан. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэл бүрээр чанарын шалгуур үзүүлэлтийг боловсруулах ажлыг 2025 оны 06 сараас эхлүүлсэн. Уг ажлын хүрээнд: Клиник, тасаг нэгжийн чанарын багийн ахлагч нарт “Чанарын шалгуур үзүүлэлт боловсруулах нь” мэдээлэл сургалт зохион байгуулж нийт 16 чанарын багийн ахлагч оролцсон. Өгсөн мэдээлэлд суурилан 2025 оны 08 сард чанарын багуудын оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 32 эмч, ахлах сувилагч оролцсон.	100%

					 Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нийтлэг болон өвөрмөц үзүүлэлтийг төвийн захирлын 2025 оны А/349 тоот тушаалаар батлуулсан. (Нийтлэг 8, өвөрмөц 6 үзүүлэлтийг хавсралтаар батлуулсан)	
2.16	Олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж, стандартын баталгаажилт хийлгэх	18.0 (Үйл ажиллагааны орлого)	Стандартын баталгаажилт хийгдсэн гэрчилгээ авсан байдал	2024 онд Чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлсэн.	Олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж баталгаажилт хийлгэх бэлтгэл ажлыг ханган бүх албадууд холбогдох зураглал баримтжуулалтыг үүсгэн ажиллаж байна.	30%
Зорилт 3: Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, нийгэм хамт олны оролцоог нэмэгдүүлэн, сэтгэцийн эрүүл мэндээ хянаж сайжруулах талаар хувь хүн, хамт олны мэдлэг, чадварыг дээшлүүлэх						
3.1	Хүчирхийлэлд өртсөн болон амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр үеийнхэнд ЭМТҮ-ээ үзүүлэх ажлыг эрчимжүүлэх сургалтыг нийслэлийн эмч, мэргэжилтнүүдэд	-	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	ЭМС-ын 2023 оны 03 дугаар сарын 18-ны А/149, А/151 дүгээр тушаалыг мөрдөн ажиллаж байна.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь Монголын Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Нийгэмлэгтэй хамтран “Сургуулийн орчин дахь сэтгэл зүйн боловсролыг дэмжих” төслийн хүрээнд нийслэлийн 9 дүүргийн өрхийн эмч, сувилагч, сум, тосгоны эмнэлгийн эмч, сувилагч, эрүүл мэндийн нийгмийн ажилтнууд, яаралтай тусламжийн ажилтнууд болон хувийн хэвшлийн сэтгэцийн эрүүл мэндийн салбарын дэмжлэг үзүүлэгчид (сэтгэл зүйн зөвлөгч, сайн дурын ажилтан), ерөнхий боловсролын сургууль, олон нийтийн байгууллагын нийгмийн ажилтнууд, залуучуудтай ажилладаг ТББ-ын төлөөлөл зэрэг анхан	100%

	зохион байгуулах /БСТ 1.1.3/				шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ажилтнуудаас бүрдсэн 100 хүнд сэтгэл зүйн боловсрол олгох зорилготой “Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх заавар” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгууллаа. 	
3.2	Боловсролын салбарын сэтгэл зүйч нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах /БСТ 1.1.4/	-	Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	2024 онд ЕБС, СӨБ-ийн багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эцэг эх, асран хамгаалагч нарт зохион байгуулсан	Дорнод аймгийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчдийг мэргэшүүлэх сургалтад хамруулсан бөгөөд сэтгэл зүйчдийг багаар ажиллаж хүүхэд, өсвөр үе залуучуудад сэтгэл зүйн хувьд тулгамдаж буй сэтгэл гутрал, стресс, түгшүүр, донтолт, өөртөө итгэлтэй байдал, харилцааны болон сэтгэл зүйн бусад асуудал, бэрхшээлээ ойлгох, сэргийлэх, даван туулахад туслах, чиглүүлэх зорилготой арга зүйн 3 хоногийн сургалтад хамруулсан. Сургалтанд ЕБС-ийн 30 сэтгэл зүйч нар хамрагдсан. 	100%
3.3	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхээс урьдчилан	-	Зохион байгуулсан сургалтын тоо,	-	“Мансуурлаас сэргийлэх олон улсын Коломбо хөтөлбөр”-ийн дагуу “Донтох эмгэгийн зөвлөгч” нарыг бэлтгэх “Баримжаа олгох” сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 19,	100%

	сэргийлэх сургуульд суурилан боловсролын салбарын сэтгэл зүйч нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах /БСТ 1.1.4/		хамрагдсан хүний тоо		20-ны өдрүүдэд тус төвийн “Эрдмийн өргөө”-нд зохион байгуулсан бөгөөд Монгол Улсын Багшийн их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн сэтгэл судлалын багш нар, Энэрэл анагаах ухааны коллежийн сэтгэцийн эрүүл мэндийн багш болон Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйч мэргэжилтэй 30 хүн хамрагдсан.	
3.4	Хүн амд зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулах /БСТ 1.2.4/	-	Мэдээлэл, сургалт, сурталчилгаа ны хандалтын тоо	Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрд аян (бүрэн хэмжээний 20 бичлэг, 10 видео хичээл, 60 постер мэдээлэл) хийсэн.	Хүн амд зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт болон сургалтын мэдээллүүдийг олон нийтэд өөрийн цахим хуудсуудаараа дамжуулан хагас жилийн хугацаанд нийт 100-120 мянган хүнд амд сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. 2025 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр Тагнуулын ерөнхий газрын алба хаагчдад “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, мөрийтэй тоглоомд донтогч болон сэтгэцийн эмгэгтэй иргэний шинж тэмдэг” сэдвээр мэдээлэл өгсөн. 2025 оны 4 дүгээр сарын 6-ний өдөр “Хобби олон улсын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад “Электрон тамхины хор хөнөөл” сэдвээр мэдээлэл өгсөн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нийт хорих анги, алба нэгжийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжил, арга зүйгээр хангах, мэдлэг ур, чадварыг дээшлүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор 2025 оны 4 дүгээр сарын 16-ний өдөр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн шинж тэмдэг” сэдвээр мэдээлэл өгсөн. Тус сургалтад цахим хэлбэрээр 70, танхимаар 52 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. 2025 оны 4 дүгээр сарын 28,29-ний өдрүүдэд Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдад, 2025 оны 5	100%

					дугаар сарын 01-нээс 03-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдад болон Политехникийн коллежийн 1,2,3 дугаар курсийн оюутнуудад “Мансууруулах бодисын хор хөнөөл” сэдвээр тус тус мэдээлэл өгсөн. 2025 оны 4 дүгээр сарын 28,29-ний өдрүүдэд Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Хилийн цэрэг, Төмөр зам, Цэрэгжүүлсэн хамгаалалтын алба хаагчдад “Мансууруулах бодисын шалтгаант сэтгэцийн эмгэгүүд”, “Мөрийтэй тоглоомд донтох эмгэг” сэдвээр тус тус мэдээлэл өгсөн. 2025 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Сайншанд сумын Тамгийн газрын ажилтнуудад “Мансууруулах бодисын шалтгаант сэтгэцийн эмгэгүүд” сэдвээр мэдээлэл өгсөн. 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулсан “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын сэтгэл зүйчдийн нэгдсэн зөвлөгөөн”-ний үйл ажиллагааны хүрээнд нийт 172 сэтгэл зүйчид “Донтолтыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх нь” сэдвээр мэдээлэл өгсөн. 2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 421 дүгээр Нээлттэй хорих ангийн алба хаагчдад “Мансууруулах бодисын шалтгаант сэтгэцийн эмгэгүүд”, мөн тус ангид мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдож ял эдэлж буй 24 хоригдолд 2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр “Мансууруулах бодист донтох эмгэгийн тухай суурь ойлголт”, 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр 25 хоригдолд “Мансууруулах бодисын хор хөнөөл”, 2025оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 19 хоригдолд “Мансууруулах бодисын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэг” тус тус мэдээлэл өгсөн. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь "Гэрлийн хурдаар өсөн дэлгэрэх эрч академи" Төрийн бус байгууллагтай хамтран Хан-Уул дүүргийн 115, 75, 52, 15,	
--	--	--	--	--	---	--

					18,130, 32 дугаар сургуулийн ахлах ангийн (9–12-р анги) нийт 540 сурагчидад “Донтолт ба Өсвөр нас” сэдэвт сургалтыг 80 минутын хугацаатай, танхимын буюу интерактив аргаар зохион байгуулсан. Сургагч багшаар Хүүхэд өсвөр үеийн асуудал хариуцсан мэргэжилтэн, эмч Г.Хулан ажилласан. Сурагчдын дунд донтолттой холбоотой ойлголт, мэдлэг 60%-аас дээш нэмэгдсэн. (урьдчилсан ба дараах асуулгын дүнгээр) Сэлэнгэ аймагт 2025 оны 6 дугаар сарын 23, 2025 оны 7 дугаар сарын 2-ны өдрүүдэд Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан “Хяналт шалгалт хийх, төлөвлөгөөт хяналт шалгалт”-ын бүрэлдэхүүнд С.Байгальмаа эмч ажиллаж сэтгэцийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон 309 иргэнийг дахин магадалж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилласан.	
3.5	Сэтгэцийн эрүүл мэндийн олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах /БСТ 1.2.1/	-	Олон улсын эрдэм шинжилгээний хурлын тайлан, оролцсон эмнэлгийн мэргэжилтний тоо	Үндэсний чуулган 2024 онд нийт 600 гаруй мэргэжилтнүүдийн хамруулан зохион байгуулсан.	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр “Сэтгэцийн эрүүл мэнд 2025” Амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх шийдвэр гаргах түвшний хэлэлцүүлэг, олон улсын эрдэм шинжилгээний хурлыг амжилттай зохион байгууллаа. Хуралд Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Турк улс, Оросын Холбооны Улс, Япон зэрэг улсуудаас нийт 10 эрдэмтэн, судлаач оролцсон бөгөөд Монгол Улсын 21 аймаг, 9 дүүргийн эмнэлгийн байгууллага, олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудын шийдвэр гаргах түвшний мэргэжилтнүүд, эмч, сувилагч, сэтгэл засалч, сэтгэл зүйч, багш, судлаач, оюутан залуус, мэргэжилтнүүд зэрэг нийт 400 орчим хүн хамрагдлаа. Амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх шийдвэр гаргах түвшний хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулснаар дараах үр дүнд хүрсэн. Үүнд: Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь хурлын хүрээнд гарсан нэгдсэн зөвлөмжийг танилцуулж Монгол Улсын Их	100%

					Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах албан бичгийг хүргүүлсэн. Олон улсын туршлага, бодлогын чиг хандлагыг хуваалцсан. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Турк улс, Оросын Холбооны Улс, Япон зэрэг улс орны мэргэжилтнүүдийн илтгэлээр дамжуулан амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх, бүртгэл мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх талаар олон улсын бодлого, судалгааны аргачлал, үр дүнг танилцуулсан. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, хууль сахиулах, батлан хамгаалах зэрэг байгууллагуудын шийдвэр гаргагч нар, төлөөлөллүүд оролцож, амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрт салбар дундын оролцоог тодорхойлон, хамтын ажиллагааг бэхжүүлсэн. Сэтгэцийн эрүүл мэнд, тархи судлалын салбарын эрдэмтэн судлаачдын сүүлийн үед хийгдсэн судалгаатай танилцаж, мэргэжилтнүүд талбарын туршлага солилцсон.	
3.6	Аймаг, дүүрэг, сум, өрхийн түвшинд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр Сэтгэц, мэдрэл, донтолт (mhGAP)-ын нэн шаардлагатай тусламж үйлчилгээний удирдамжийг хэрэгжүүлэх	-	Сургалтын тайлан, бэлтгэгдсэн сургагч багш, суралцагчийн тоо	2024 онд 15 аймаг, нийслэлийн 5 дүүргийн түвшинд Сэтгэц, мэдрэл, донтолт (mhGAP)-ын нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж, 657 эмч,	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь Эрүүл мэндийн яам, аймгуудын эрүүл мэндийн газар болон архийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр 2025 оны 7 сарын 26-наас 11 дүгээр сарын 5-ны өдрүүдэд Ховд, Баян-Өлгий, Хөвсгөл аймгууд, Чингэлтэй дүүрэгт анхан шатны тусламж үйлчилгээнд ажиллаж буй эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд “Сэтгэц, мэдрэл, донтолт тусламж үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх” сургалтыг амжилттай зохион байгууллаа. Сургалтанд зорилтот дүүрэг, орон нутгийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн газар, өрхийн эрүүл мэндийн төв, сум, сум дундын эмнэлгийн эрүүл мэндийн төвийн нийт 242 эмч, сувилагч, эрүүл мэндийн мэргэжилтнүүд хамрагдсан болно.	100%

	/БСТ 1.2.1/			мэргэжилтэнд сургалт хийгдсэн.		
3.7	Мансуурлын эмчилгээний Коломбо хөтөлбөр (The Colombo plan)-ийг үргэлжлүүлэх хэрэгжүүлэх /БСТ 1.2.2/	-	Хэрэгжилтийн явц, тайлан	2023 онд Олон улсын түвшний ICAP-1 эмчилгээний анхан шатны 2 багш бэлтгэгдсэн.	“Мансуурлаас сэргийлэх олон улсын Коломбо хөтөлбөр”-ийн дагуу “Донтох эмгэгийн зөвлөгч” нарыг бэлтгэх “Баримжаа олгох” сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд тус төвийн “Эрдмийн өргөө”-нд зохион байгуулсан бөгөөд аймаг, нийслэлийн анхан ба лавлагаа шатлалын эмнэлэг, эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлэгт донтох эмгэг судлалын чиглэлээр ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, нийгмийн ажилтнууд, сэтгэл зүйчид, өөртөө туслах бүлгийн гишүүд болон их, дээд сургууль, коллежийн багш нар зэрэг нийт 35 мэргэжилтэн хамрагдсан. Сургалтыг сэтгэцийн зөвлөх зэргийн эмч, АУ-ны магистр, ICAP-1 (International Certified Addiction Professional-1) К.Елена, Сургалтыг сэтгэцийн тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны магистр, Б.Энхчимэг, сэтгэцийн тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны магистр, ICAP-1 (International Certified Addiction Professional-1) Е.Гүлжанат, сэтгэцийн ахлах зэргийн эмч, АУ-ны магистр С.Байгальмаа, сэтгэцийн ахлах зэргийн эмч, АУ-ны магистр С.Байгальмаа, сэтгэцийн ахлах зэргийн эмч Д.Баттөр нар удирдан явуулсан.	100%

3.8	Архи, электрон болон утаат тамхины хор нөлөө, дам тамхидалтын нөлөө, цахим мөрийтэй тоглоомын хор уршгийг олон нийтэд сурталчлах, соён гэгээрүүлэх, ухуулга нөлөөллийн ажлыг эрчимжүүлж, тогтмолжуулан, татгалзах сэдлийг дэмжих, сурталчлах, зөвлөгөө өгөх сургалт явуулдаг төрийн болон ТББ, олон нийтийн хөдөлгөөнийг дэмжих /БСТ 1.1.2/	-	Сургалтад хамрагдсан хүний тоо, цахим орчинд түгээсэн мэдээ мэдээлэл, видео контентын тоо, түүнийг үзсэн, түгээсэн тоо	Архи, электрон болон утаат тамхины хор нөлөө, дам тамхидалтын нөлөө, цахим мөрийтэй тоглоомын хор уршгийг олон нийтэд сурталчлах ажлыг нийт 22 удаа тогтмол зохион байгуулсан.	Олон нийтэд тамхи, электрон тамхины хор хөнөөлийг таниулах, тамхинаас хэрхэн татгалзах зөвлөгөө контент, social media постер Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн пейж хуудас, Олон нийтэд тамхи, электрон тамхины хор хөнөөлийг таниулах, тамхинаас хэрхэн татгалзах зөвлөгөө контентын хүрээнд нийт 14 social media постер хийгдсэн. Постер тус бүр өөр өөр өнгө үзэмж, утга агуулгатай. 2025 оны 05 сарын 31-ны өдрөөс дараах төлөвлөгөөний дагуу постер болон богино бичлэг, reels гэж 7 хоногт хуваарийн дагуу Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн пейж хуудсаар цацагдсан. 2025 оны 6-р сарын 4-ний өдөр нийтлэгдсэн “Амт нь донтоход оруулах урхи юм” гарчигтай сошиал пост нь нийт 4,065 хандалт авсан бөгөөд нийт 83 харилцан үйлдэл (engagement) бүртгэгдсэн байна. Үүнээс 22 лайк, 16 хуваалцалт, 0 сэтгэгдэл бүртгэгдсэн. 2025 оны 6-р сарын 2-ны өдөр нийтлэгдсэн “Бохь, манго, эсвэл чихэр шиг амт-эдгээр нь амт биш, урхи юм” нэртэй сошиал пост нийт 5,914 хандалт авч, 105 харилцан үйлдэл (engagement) бүртгэгдсэн байна. Үүнд 33 лайк, 21 хуваалцалт, 1 сэтгэгдэл багтсан бөгөөд постын агуулга хэрэглэгчдийн анхаарлыг тодорхой хэмжээнд татсан болохыг харуулж байна. Уг постоор дамжуулан 4 шинэ дагагч нэмэгдсэн нь харьцангуй эерэг үр дүнтэй бөгөөд тухайн агуулга зарим хэрэглэгчдэд итгэл төрүүлж, дагагч болоход нөлөөлсөн байна. 2025 оны 5-р сарын 31-наас 6-р сарын 13-ны хооронд сошиал платформ дахь нийт харилцан үйлдлийн тоо 1,214 хүрсэн нь өмнөх 14 хоногтой харьцуулахад 102%-иар өссөн үзүүлэлттэй байна. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн пейж хуудасны хандалт дагагчдын тоо 26,649 хүрч, өмнөх 14 хоногоос 1%-иар өссөн байна.	100%
3.9	Дэлхийн	-	Ажлын тайлан	Жил бүр	Сэтгэц-Нийгмийн эрүүл мэнд, алба дэлхийн тамхигүй	100%

	тэмдэглэлт өдрүүд (архи, тамхи, мансууруулах бодис, амиа хорлолт, сэтгэцийн эрүүл мэндийн гэх мэт)-ийг тэмдэглэх сурталчилгааны ажил зохион байгуулах			тодорхой уриа дор зохион байгуулдаг.	өдрийг тэмдэглэн өнгөрөөх “Тамхины үнэнийг илчилъе” нөлөөллийн ажлыг Улаанбаатар цэцэрлэгт хүрээлэн “Рио Тинто”-ийн Задгай театрд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр, 16:30-18:30 цагт зохион байгуулагдсан. Энэ жилийн Дэлхийн Тамхигүй Өдрийн уламжлалт арга хэмжээ нь 2025 онд "Худалд хууртаж болохгүй!, Тамхины үнэнг илчилъе!" уриатайгаар зохион байгуулагдсан бөгөөд Тамхи ба никотин агуулсан бусад бүтээгдэхүүн буюу электрон тамхины үйлдвэрлэл, борлуулалт нь өнөөгийн нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудын нэг болсон бөгөөд ялангуяа залуу үеийн сонирхлыг татах зорилгоор бүтээгдэхүүнүүдийн бодит шинж чанарыг нууцлах, сонирхол татахуйц болгох арга хэмжээнүүд түгээмэл хэрэглэгддэг байна. Эдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэлд амт, үнэрийг сайжруулах, гадаад төрхийг өөрчлөх зорилгоор нэмэлт бодисуудыг ашигладаг бөгөөд үүнээс үүдэн тамхины бодит чанарыг далдлах, амтыг сайжруулах замаар хүүхэд залуучуудад зориулж тамхины сэтгэл татам байдлыг нэмэгдүүлэх зэрэг үр дүнд хүрдэг байна. Энэхүү арга замууд нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй гэж хүлээн зөвшөөрөгдөж байгаа бөгөөд үүнийг илчлэх, хэрэгжүүлэхгүй байхын тулд олон нийтийн зөв мэдээлэл хүргэх, хууль эрх зүйн арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байгаа юм. Иймд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл Мэндийн Яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл Монгол Хүн үндэсний хөдөлгөөн, боловсролын ерөнхий газар, Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, ANSA Mongolia-тай хамтран хүүхэд залуучуудад тамхи ба электрон тамхины хор хөнөөлийг таниулах, тамхинаас гаргах эмчилгээ, зөвлөгөө сургалт зохион байгуулах, электрон тамхины хэрэглээний бодит аюулын тухай олон нийтэд зөв мэдээлэл хүргэж, электрон тамхи ба тамхин бүтээгдэхүүний хэрэглээнээс сэргийлэх зорилгоор олон нийтэд уриалсан арга хэмжээ зохион байгуулагдсан. Хүүхэд, өсвөр үе болон залуучуудад нотолгоонд суурилсан мэдээлэл өгч, тамхи, никотины	
--	--	--	--	--	---	--

					бүтээгдэхүүний хор хөнөөлийн талаарх мэдлэгийг дээшлүүлсэн. Сэтгэцийн эрүүл мэндийн дэлхийн өдрийг тохиолдуулан НҮБ-ийн Хүн амын сангийн санхүүжилтээр Гэрэл Медиа групптэй хамтран 2025 оны 09 сарын 29-ний өдрөөс 2025 оны 10 сарын 29 өдрүүдэд 10-19 насны өсвөр үе болон залуусыг “Сонсох, ойлгох, тусламж авах” нөхцөлийг хангасан аюулгүй, ойлгомжтой, дэмжигдсэн нийгмийн уур амьсгалыг бүрдүүлж, сэтгэлзүйн тусламж дэмжлэг авах боломжийг нэмэгдүүлэх зорилготой “Сэтгэл ч бас өвддөг, анзаараарай” уриатай “Сэтгэл бол Эрхтэн” нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэв. Нөлөөллийн ажлын хүрээнд Edu Park-д 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Сэтгэлээ чагнах өдөр арга хэмжээг зохион байгуулж, зорилтот бүлэгт хүргэх зорилгоор Сэтгэл засалч эмч Р.Энхтүвшин, "Master Brain Mongolia" ХХК-ийн Сэтгэл засалч эмч, Донтох эмгэг судлаач Ж.Гантулга, “Андра” хувь хүний хөгжлийн академийн гүйцэтгэх захирал, мисс, топ модель Х.Бадамгэрэл, Дале Карнегийн Монгол дахь салбарын үүсгэн байгуулагч, Олон улсын мастер сургагч багш Э.Чинзориг нар лекц уншив. Үйл ажиллагааны дараа СЭМҮТ-ийн эмч нар хүүхэд, залуучуудад сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн бөгөөд нөлөөллийн ажлын шторкийг сошиал орчинд зохион байгуулагчдын үндсэн хаягаар нийтэлсэн бөгөөд нийт үзэлт 35,000 хүнд хүрсэн байна.	
3.10	СЭМҮТ-ийн веб, фейсбүүк хуудас, юүтүб болон хэвлэл мэдээллийн байгууллагаар /телевиз, сайт, сонин, ФМ радио/ зэрэг сэтгэцийн эрүүл мэндийн	-	СЭМҮТ-ийн веб, фейсбүүк хуудас, юүтүб хуудасны хандалтын тоо	Facebook пейж, Youtube сувгаар 351 гаруй видео контент, зөвлөмж, постер мэдээлэл нийтэлснээс нийт	Тус төвийн цахим хуудсаар /нүүр ном/ дамжуулан 2025 оны 12 дугаар сарын байдлаар 351 видео контент, зөвлөмж, постер мэдээллийг олон нийтэд түгээсэн. Нийт хандалтын тоо 4,360,238 байгаа бөгөөд цахим хуудасруу хандаж байгаа хүмүүсийн 85 хувь нь дагагч нар, 15 хувь нь дагагч биш хүмүүс үзэж байна. Тайлант хугацаанд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн цахим хуудас нь 10,879 дагагчтай байна. Нийтдээ 183,671 шэйр, лайк, сэтгэгдэл авчээ. 428 удаагийн давталттай асуултад хариулт өгсөн байна.	100%

	талаар тогтмол мэдээлэл түгээх /БСТ 1.2.4/			хандалтын тоо - 4,360,238, дагагчдын тоо 10,879 болж нэмэгдсэн, Youtube сүлжээгээр 89 видео контент түгээсэн. 27,405 болж нэмэгдсэн байна.	Youtube сувгаар энэ оны эхний хагас жилийн байдлаар 69 видео оруулжсан. 27,405 дагагчтай байна. Цахим хуудсаараа дамжуулан 64 мэдээ оруулжээ. 2025 оны 12 дугаар сарын байдлаар 89 төрлийн ярилцлага, мэдээ, тодруулгыг isee.mn, zarig.mn, asu.mn, gerel.mn, ikon.mn, news.mn зэрэг сайтуудаар олон нийтэд түгээсэн. 112 төрлийн ярилцлага, тодруулга, подкаст зэргийг Монголын үндэсний телевиз, HDMongol, Малчин ТВ, Eagle ТВ, C1, NTV, SBN, ТВ5, ТВ25, ТВ9, Manpodcast, Dr Unuruu зэрэг телелвиз, подкастуудаар хүргэжээ. Мөн Эрүүл мэндийн яам, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Adra Mongol, Дотоод хэргийн их сургууль, Улсын Мөрдөн Байцаах газар зэрэг байгууллагуудын хэвлэлийн албатай хамтарч ажиллалаа.	
3.11	Аутизмыг эрт оношлох, аутизмтай хүнийг хүчирхэгжүүлэх, амьдрах ухааны ур чадвар олгох, нийгэмшүүлэх /БСТ 2.2.5/	-	Аутизм өвчнийг эрт илрүүлж оношлох ADOS-2 оношилгооны аргыг нэвтрүүлж, СЭМҮТ-ийн хүүхдийн эмч нарт ADOS-2- ыг хэрхэн ашиглах сургалт орж хүний нөөцөө бэлтгэсэн байна.	Аутизм өвчнийг эрт илрүүлж оношлох ADOS-2 оношилгооны аргыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна.	“Монгол Улсад эмчлэгддэггүй өвчлөлийг бууруулах бодлого”-ын хүрээнд хүүхдийн сэтгэцийн эмч нар Бүгд Найрамдах Турк Улсад Аутизмын оношилгоо, үнэлгээний “ADOS-2” аргачлалын онол болон дадлага сургалтад хамрагдсан юм. Тэдгээр эмч нар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд аутизмын хүрээний эмгэгийн оношилгооны олон улсын стандарт аргачлал болох “ADOS-2” оношилгоо, үнэлгээний аргачлалын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн оношилгоо хийж эхэлсэн. ADOS-2-ыг хэрхэн ашиглах сургалтыг Бүгд найрамдах Турк улсын Трабзон Их Сургуулийн сэтгэцийн тасгийн эрхлэгч, профессор, хүүхдийн сэтгэцийн эмч Онур Бурак Дурсун удирдан 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс 14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Монголын Сэтгэцийн Эрүүл Мэндийн Нийгэмлэг хамтран “Childhood Autism Rating Scale-2” оношилгоо, үнэлгээний арга зүйн сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Анагаахын	100%

					шинжлэх ухааны их сургуулийн байрны Эрдмийн сургуулийн лекцийн танхимд зохион байгуулсан. Энэхүү сургалт нь хүүхдийн сэтгэцийн хөгжлийн эмгэгийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх орчин үеийн арга зүйг мэргэжилтнүүдэд танилцуулах, мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлэх зорилготой байсан бөгөөд Монгол Улсын 21 аймаг болон Улаанбаатар хотын есөн дүүргээс сэтгэцийн эмч, сэтгэл зүйч зэрэг нийт 58 мэргэжилтэн хамрагдсан юм. Сургалтыг Бүгд найрамдах Турк улсын сэтгэцийн эмч, профессор Онур Бурак Дурсун, хүүхдийн сэтгэцийн эмч Б.Сэлэнгэ, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хүүхэд өсвөр үеийн клиникийн эрхлэгч Л.Цэрэндолгор удирдан явуулсан.	
3.12	Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед нийгэм, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх сургагч багш болон сайн дурын ажилтан бэлтгэх	-	Гамшгийн үед нийгэм, сэтгэц-зан үйлийг төлөвшүүлэх сургагч багш, сайн дурын ажилтнууд бэлтгэгдсэн байна.	2024 онд Гамшгийн үед нийгэм, сэтгэц-зан үйлийг төлөвшүүлэх сургагч багш, сайн дурын 30 ажилтан бэлтгэгдсэн байна.	Гамшгийн үед нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сайн дурын ажилтан бэлтгэх олон улсын сургагч багш бэлтгэх сургалтад П.Энх-Учрал хамрагдаж Үндэсний сургагч багш болон сайн дурын ажилтан бэлтгэхэд ашиглах гарын авлагыг Монголын Улаан Загалмай нийгэмлэгтэй хамтран боловсруулсан.	100%

					Монголын улаан загалмай нийгэмлэг, Япон Улсын улаан загалмай нийгэмлэг, 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрүүдэд хамтран зохион байгуулсан Үндэсний сургагч багш бэлтгэх сургалтад Л.Мөнхтуяа, Л.Эрдэнэсүвд нар хамрагдсан.
--	--	--	--	--	--

				Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөтөлбөрийн санхүүжилтээр “Тогтвортой санхүүжилт” ХХК-тай хамтран дэлхийн 45 оронд хэрэгждэг Mental Health First Aid /MHFA/ буюу Сэтгэлзүйн эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх олон улсын хөтөлбөрийн сургагч багш бэлдэх эхний сургалтыг 2025 оны 10 сарын 06-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрүүдэд хамтран зохион байгуулсан бөгөөд сургалтанд хувийн хэвшлийн болон мэргэжлийн байгууллагын төлөөлөл болон олон нийтийн төлөөлөлөөс бүрдсэн 35 хүн хамрагдсан.
--	--	--	--	--

						
3.13	Хүүхэд өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааны цогц төлөвлөгөө боловсруулж батлуулах /БСТ 1.1.1/	-	Хүүхэд өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааны цогц төлөвлөгөө боловсруулж, УИХ-аар батлуулсан байна.	Хүүхэд өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааны цогц төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бэлтгэл ажил хангагдсан.	Хүүхэд өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагааны цогц төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд 2025 оны 6-р сарын 16-ны өдөр Эрүүл мэндийн яамны хурлын "Б" зааланд салбар хороодын хурлаар үйл ажиллагааны цогц төлөвлөгөөг хэлэлцүүлж, хурлын үр дүнг үндэслэн санал аваад, Боловсролын яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар ажлын хэсэг ажиллаж байна.	50%

3.14	Амиа хорлолтын түвшинг үр дүнтэй бууруулах төлөвлөгөө боловсруулж, батлуулах /БСТ 1.1.3/	-	Амиа хорлолтын түвшинг үр дүнтэй бууруулах төлөвлөгөө боловсруулж, батлуулан хэрэгжүүлж эхэлсэн байна.	Амиа хорлолтын түвшинг үр дүнтэй бууруулах төлөвлөгөө боловсруулж, батлуулах бэлтгэл ажил хангагдсан.	Амиа хорлолтын түвшинг үр дүнтэй бууруулах төлөвлөгөө боловсруулж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын бүсийн зөвлөхүүд болон суурин төлөөлөгчтэй хамтран амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг зохион байгуулагдаж Эрүүл мэндийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, Батлан хамгаалах яам, Соёл, спорь, аялал жуулчлал, залуучуудын яам, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамны холбогдох мэргэжилтнүүдээс санал авсан. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хурлаар 2025 оны 10 дугаар сарын 20-нд амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг хэлэлцүүлсэн. Хурлаас гарсан саналыг тусган холбогдох засваруудыг хийсэн. Төлөвлөгөөний сүүлийн хувилбарыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлж ажилласан.	70%
3.15	ДЭМБ-ын Сэтгэц, мэдрэл, донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хөтөлбөр /mhGAP/-ийг удирдамж боловсруулах, бэлтгэл ажлыг хангах /БСТ 1.2.1/	-	ДЭМБ-ын Сэтгэц, мэдрэл, донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хөтөлбөр /mhGAP/-ийг удирдамж болгон оруулсан байна.	ДЭМБ-ын Сэтгэц, мэдрэл, донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хөтөлбөр /mhGAP/-ийг орон нутгийн түвшинд удирдамж болгон оруулах ажлын бэлэн байдлыг хангасан байна.	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Сэтгэц, мэдрэл, донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хөтөлбөр /mhGAP/-ийн удирдамжийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийг боловсруулсан байна.	50%
3.16	Урьдчилан сэргийлэх, эрт	-	Урьдчилан сэргийлэх, эрт	Эрүүл Монгол хүн хөдөлгөөн	"Эрүүл Монгол хүн" хөдөлгөөний хүрээнд "Архины шалтгаант эмгэгийн илрүүлэг ба тусламж үйлчилгээний	100%

	илрүүлэх, эмчилгээнд хамрагдахыг сэдэлжүүлэх удирдамж, заавар боловсруулж анхан шатны эрүүл мэндийн байгууллага болох Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд архины хэрэглээний эрсдэлтэй үйлчлүүлэгчдийг AUDIT сорилоор илрүүлэх.		илрүүлэх, эмчилгээнд хамрагдахыг сэдэлжүүлэх удирдамж, заавар боловсруулж АУДИТ сорилыг оруулах.	хамтран SAFER хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх судалгааг хийсэн ба “F” үсэг буюу “Эрт илрүүлэг, товч арга хэмжээ болон эмчилгээд хамрагдалтыг хөнгөвчлөх “бүрэлдэхүүн хэсэгт AUDIT сорилыг ашиглах зөвлөмж гарсан.	уялдаа” сэдвээр 7 удаагийн сургалтанд нийслэлийн 9 дүүргээс 466 байгууллагын төлөөлөл нийт 825 хүн хамрагдаж амжилттай зохион байгууллаа. Энэ сургалтанд дүүргийн Засаг даргын тамгын газар, нийгмийн бодлогын хэлтэс, цагдаагийн бие бүрэлдхүүн, дүүргийн хороо ба хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан, дүүргийн эрүүл мэндийн төв болон Өрхийн эрүүл мэндийн төвийн төлөөлөл оролцож, архины хэрэглээний эрсдэлтэй үйлчлүүлэгчдийг AUDIT сорилоор илрүүлэх мэдлэгтэй болсон. Архины шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэгийн зааврыг боловсруулж, анхан шатанд архины хэрэглээний эрсдэлтэй үйлчлүүлэгчдийг AUDIT сорилоор илрүүлэх аргачлалыг оруулсан. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Сэтгэц, мэдрэл, донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хөтөлбөр /mhGAP/-ийн удирдамжийг боловсруулахад анхан шатанд архины хэрэглээний эрсдэлтэй үйлчлүүлэгчдийг AUDIT сорилоор илрүүлэх агуулгыг тусгасан болно.	
--	---	--	--	---	--	--

Зорилт:4: Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлс, зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тандалтыг сайжруулна

4.1	“Сэтгэцийн эрүүл мэнд” цогц арга хэмжээний төлөвлөгөө”г хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөөний үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөг боловсруулсан.	"Сэтгэцийн эрүүл мэнд" 2024-2027 арга хэмжээний төлөвлөгөө 2025 онд төлөвлөсөн үйл ажиллагааг үнэлэхэд хэрэгжилтийн явц 100 хувьтай байна.	100%
4.2	“Сэтгэцийн эрүүл мэндийн үзүүлэлт” эмхэтгэл боловсруулж түгээх	1,5 (Үйл ажиллаг ааны орлого)	Сэтгэцийн эрүүл мэндийн эмхэтгэл хэвлүүлж түгээсэн тоо	2023 онд эмхэтгэл хийж, 100 ширхгийг түгээж байсан.	“Сэтгэцийн эрүүл мэндийн үзүүлэлт 2020-2024” эмхэтгэл боловсруулж цахим хэлбэрээр түгээсэн. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн цахим сайтад олон нийтэд нээлттэй хэлбэрээр байршуулсан.	100%
4.3	Мэдээллийн технологийн апп ашиглан,	50,0 (ДЭМБ)	Судалгааны тайлан	-	Мэдээллийн технологийн аппейкшн ашиглан согтууруулах ундааны хэрэглээг багасгах, хянах туршилт судалгаа хийх ажил хийгдэж байна.	100%

	согтууруулах ундааны хэрэглээг багасгах, хянах туршилт судалгаа хийх				Цахим сайтад байршуулсан согтууруулах ундааны хэрэглээний түвшин, авах арга хэмжээг тодорхойлох AUDIT сорил авсан https://ncmh.gov.mn/. 2025 онд энэхүү сорилыг нийт 1338 хүн бөглөсөн бөгөөд дундаж нас 26.15±7.5 байсан бол хүйсийн хувьд 55.2% (n=738)-ийг эмэгтэйчүүд, 44.8% (n=600)-ийг эрэгтэйчүүд эзэлж байлаа 14-56 насны нийт 440 хүн бөглөсөн. Үүнд: 22 хувь архи хэтрүүлэн хэрэглэгч буюу аюултай хэрэглээний түвшинтэй /архины хэрэглээний талаар мэдлэг, боловсрол олгох шаардлагатай/ 21 хувь архи хэтрүүлэн хэрэглэгч буюу хортой үр дагавар өгөхүйц хэрэглээний түвшинтэй / богино хугацааны ярилцлага, хяналтанд орох шаардлагатай/ 57 хувь архины хамааралд орсон /нарийн мэргэжлийн эмчийн зөвөлгөө, эмчилгээ шаардлагатай/ гэж дүгнэгдсэн байна. Энэхүү сэтгэлзүйн сорилыг Андроид болон IOS системд зориулсан аппликейшиныг байршуулан ажиллаж байна.	
4.6	Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгаа хийх /БСТ 1.2.1.5/	-	Судалгаа хийгдсэн байна	Mini-International Neuropsychiatric Interview (M.I.N.I) буюу мэдрэл-сэтгэцийн эмгэгийг оношлох ярилцлага асуумжийн хүчин хийж, Монгол улсын зарим бүс нутгуудад 18-64 насны хүн амын дунд түгээмэл	Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгаа хийх бэлтгэл ажлыг хангах зорилгоор сэтгэцийн эмгэгийг оношлоход олон улсад түгээмэл хэрэглэдэг Mini-International Neuropsychiatric Interview (M.I.N.I) буюу мэдрэл-сэтгэцийн эмгэгийг оношлох ярилцлага асуумжийн хүчин төгөлдөр байдлыг үнэлэх судалгааны ажил хийгдэж байна. Одоогоор судалгааны цуглуулсан мэдээлэл дээр статистик анализ хийгдэж байгаа болно. Нэгдүгээр шат: (Хэл зүйн нутагшуулалт): сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн эмч нар, Анагахийн шинжлэх ухаахааны үндэсний их сургуулийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхимийн багш нар, хэл судлаач, сэтгэл судлаач, соёл судлаач гэсэн бүрэлдэхүүнтэй баг хэл зүйн нутагшуулалтыг: 1) Мэдрэл сэтгэцийн эмгэгийг оношлох ярилцлага хийх M.I.N.I. асуумжийн Монгол хувилбарыг (M.I.N.I.-MNG) боловсруулах 2) Мэдрэл сэтгэцийн эмгэгийг оношлох ярилцлага хийх	100%

				тохиолддог сэтгэцийн эмгэгийн тархалтыг үнэлэх цогц судалгааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан.	M.I.N.I.-MNG асуумж дээр урьдчилсан судалгаа хийх гэсэн дарааллаар нийт 5 үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Хоёрдугаар шат: (Асуумжийн хүчин төгөлдөр байдлыг үнэлэх): Монгол улсын нийгэм эдийн засаг, газарзүйн онцлогийг төлөөлөхийн тулд Улаанбаатар хот болон бүс нутгууд гэж хуваан сэтгэц судлалын үндсэн мэргэшил эзэмшээгүй эмч, судлаачдын баг болон сэтгэцийн эмч, мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан туршлагатай, мэргэжлийн зэрэгтэй эмч, багш нарын баг судалгааны мэдээллийг цуглуулсан. Бүс нутгийн хувь баруун бүсээс Ховд, Хангайн бүсээс Хөвсгөл, Зүүн бүсээс Дорнод, Говийн бүсээс Өмнөговь аймгуудыг санамсаргүй сонголтоор сонгож авсан. Судалгааны ажлын зохицуулагч оролцогчдын өмнөх онош, өвчний түүх, нас зэрэг хувийн мэдээллийг нууцлан хадгалж, оролцогчдыг сонгож, санамсаргүй байдлаар асуумжийг авах судлаачдад хуваарилах ажлыг хийж гүйцэтгэсэн. Одоогоор судалгааны цуглуулсан мэдээлэл дээр статистик анализ хийгдэж байгаа болно.	
4.7	Эрүүл мэндийн байгууллагуудын ажилчдын “Ажлын байран дээрх сэтгэцийн эрүүл мэнд, бэлгийн дарамт”-д өртсөн эсэхийг үнэлэх судалгаа хийх	-	Эрүүл мэндийн байгууллагуудын ажилчдын “Ажлын байран дээрх сэтгэцийн эрүүл мэнд, бэлгийн дарамт”-д өртсөн эсэхийг үнэлсэн судалгааны тайлантай болно	Эрүүл мэндийн байгууллагуудын ажилчдын “Ажлын байран дээрх сэтгэцийн эрүүл мэнд, бэлгийн дарамт”-д өртсөн эсэхийг үнэлэх судалгааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан.	Судалгааг аналитик судалгааны нэг агшны судалгааны загварыг ашиглан хийсэн. Уг судалгаанд Монгол улсын 21 аймгийн 330 сум, Улаанбаатар хотын 9 дүүргийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 1895 хүнээс ажлын байран дээрх сэтгэцийн эрүүл мэндийн байдал, дарамтын нөхцөл байдлыг тодорхойлох асуумж судалгааг авсан боловч 390 эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон бусад ажилчид судалгааны картыг дутуу бөглөж судалгааны шалгуур хангаагүй шалтгаанаар хасагдсан. Иймд бид судалгааны шалгуурыг бүрэн хангасан нийт 1505 хүний судалгааны материалд тулгуурлаж тайлан бичсэн. Судалгаанд нийт 1505 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан бөгөөд тэдний 56.9 хувь нь сэтгэцийн ямар нэгэн тулгамдсан асуудалтай байсан болно. Тухайлбал, оролцогчдын 40.9 хувь нь архаг ядаргаа, 36.4 хувь нь тайлбарлах боломжгүй биеийн зовуурь, 28.4 хувь нь сэтгэл түгшилт, 26.3 хувь нь сэтгэл гутралтай байх магадлалтай байна. Архаг ядаргаа, сэтгэл гутрал нь 26–35 насны	100%

					бүлгийн дунд илүү өндөр хувьтай байна. Сумын төвд ажиллаж амьдарч буй ажилчдын дунд сэтгэцийн тулгамдсан асуудал илүү түгээмэл байгаагийн зэрэгцээ дээд боловсролтой, тэр дундаа эрдмийн зэрэг цолтой ажилчдын дунд мөн өндөр хувьтай байв. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 34.7 хувь нь архаг ядаргаатай, 20.3 хувь нь сэтгэл түгшилттэй, 25.2 хувь нь тайлбарлаж боломгүй зовиур шаналгаатай, 20.7 хувь нь сэтгэл гутралтай, 43.7 хувь нь амьдралдаа сэтгэл ханамжгүй байна. Эмэгтэйчүүдийн хувьд архаг ядаргаа 87.5 хувь, сэтгэл түгшилт 89.5 хувь, биеших эмгэг 89.8 хувь, сэтгэл гутрал 88.4 хувь зэрэг эмгэгүүд эрэгтэйчүүдээс илүү их хувьтай илэрсэн нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн ажилчдын 46.4 хувь нь амьдралынхаа туршид, 36 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд ямар нэгэн хэлбэрийн хүчирхийлэлд өртсөн гэж мэдээлжээ. Амьдралынхаа туршид хүчирхийлэлд өртсөн ажилчдын дунд сэтгэл зүйн хүчирхийлэл хамгийн өндөр (30.6) хувьтай бүртгэгдсэн бол бэлгийн хүчирхийлэлд өртсөн хувь 1.3% байв. Хүчирхийлэлд өртсөн ажилчдын дунд архаг ядаргаа, сэтгэл түгшилт, сэтгэл гутралын түвшин харьцангуй өндөр илэрсэн бөгөөд эдгээр үзүүлэлтүүд нь статистик ач холбогдол ($p=0.000$) бүхий ялгаатай гарлаа. Ажлын байран дээрх дээрэлхэлт, дарамтыг ажилчид голчлон хамтран ажиллагсад, шууд удирдлага болон үйлчлүүлэгч, тэдний ар гэрээс мэдэрсэн гэжээ. Ажлын байрны стрессийн үнэлгээгээр судалгаанд хамрагдагсдын 32.3 хувь нь тодорхой хэмжээний стресстэй байсан бол 2.8 хувь нь стрессийн түвшин нь аюултай хэмжээнд байна. Сүүлийн 12 сарын хугацаанд ажлын байран дээрээ дарамт мэдэрсэн ажилчдын дунд сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, архаг ядаргаа илүүтэй илрэв. Эрэгтэйчүүдийн 36 хувь ажлын байрны стресстэй гэж үнэлэгдсэн ба үүнээс 22.5 хувь нь бага зэргийн стресстэй, 8.6 хувь нь дунд зэргийн стресстэй, 3.2 хувь нь хүнд зэргийн стресстэй, 1.8 хувь нь	
--	--	--	--	--	--	--

					ажлын байрын стресс аюултай түвшинд байсан.	
4.8	Мэдээллийн технологийн апп ашиглан, согтууруулах ундааны хэрэглээг багасгах, хянах туршилт судалгаа хийх	-	Судалгааны тайлан	2024 онд согтууруулах ундааны хэрэглээг үнэлэх сорилыг 1354 хүн бөглөсөн	Мэдээллийн технологийн аппейкшн ашиглан согтууруулах ундааны хэрэглээг багасгах, хянах туршилт судалгаа хийгдэж байна. Цахим сайтад байршуулсан согтууруулах ундааны хэрэглээний түвшин, авах арга хэмжээг тодорхойлох AUDIT сорил авсан https://ncmh.gov.mn/. 2025 онд энэхүү сорилыг нийт 1338 хүн бөглөсөн бөгөөд дундаж нас 26.15±7.5 байсан бол хүйсийн хувьд 55.2% (n=738)-ийг эмэгтэйчүүд, 44.8% (n=600)-ийг эрэгтэйчүүд эзэлж байлаа 14-56 насны нийт 440 хүн бөглөсөн. Үүнд: 22 хувь архи хэтрүүлэн хэрэглэгч буюу аюултай хэрэглээний түвшинтэй /архины хэрэглээний талаар мэдлэг, боловсрол олгох шаардлагатай/ 21 хувь архи хэтрүүлэн хэрэглэгч буюу хортой үр дагавар өгөхүйц хэрэглээний түвшинтэй /богино хугацааны ярилцлага, хяналтанд орох шаардлагатай/ 57 хувь архины хамааралд орсон /нарийн мэргэжлийн эмчийн зөвөлгөө, эмчилгээ шаардлагатай/ гэж дүгнэгдсэн байна. Энэхүү сэтгэлзүйн сорилыг Андроид болон IOS системд зориулсан аппликейшиныг байршуулан ажиллаж байна.	100%
4.9	AUDIT сорил (Alcohol Use Disorders Identification Test) архины хэрэглээний түвшин болон архины хамааралтай холбоотой эрсдэлийг үнэлдэг сорилыг ажиллуулах үр чадварыг	-	Сургалтад хамрагдсан хүний тоо, сургалтын дараа оролцогчид хэдэн хүнд AUDIT сорил ашигласан тухай мэдээлэл цуглуулах.	2024 онд хийгдэж байгаагүй	"Эрүүл Монгол хүн" хөдөлгөөний хүрээнд "Архины шалтгаант эмгэгийн илрүүлэг ба тусламж үйлчилгээний уялдаа" сэдвээр 7 удаагийн сургалтанд нийслэлийн 9 дүүргээс 466 байгууллагын төлөөлөл болох нийт 825 хүн хамрагдаж амжилттай зохион байгууллаа. Сургалтаар дүүргийн Засаг даргын тамгын газар, нийгмийн бодлогын хэлтэс, цагдаагийн бие бүрэлдхүүн, дүүргийн хороо ба хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан, дүүргийн эрүүл мэндийн төв болон Өрхийн эрүүл мэндийн төв төлөөлөл оролцож Архинд донтох эмгэгээс сэргийлэх, тусламж үйлчилгээг өргөжүүлэх, архины хэрэглээний эрсдэлтэй үйлчлүүлэгчдийг AUDIT сорилоор илрүүлэх мэдлэгтэй болсон.	100%

	эзэмшүүлэх сургалтыг тогтмол цахим хэлбэрээр явуулах					
4.10	Сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг олон улсын дагуу боловсруулж эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэж, чадавхжуулах	-	Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	2024 онд төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн Донтолт судлал, Сэтгэл судлал, Хүүхэд, өсвөр үеийн сэтгэц судлал, чиглэлээр нийт 40 эмч бэлтгэгдсэн.	2025 онд Төрөлжсөн болон үндсэн мэргэшлийн сургалтад Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын А/147 тоот тушаал, Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн ерөнхий захирлын А/291 тоот тушаалаар Үндсэн мэргэшил-14 Донтолт судлал - 8 Сэтгэл засал судлал -11 Шүүхийн сэтгэц судлал -5 Хүүхэд, өсвөр үеийн сэтгэц судлал - 2 Эмнэл зүйн сэтгэл зүй судлал -10 Нийт 50 сэтгэцийн эмч хамрагдаж амжилттай төгссөн.	100%
Зорилт 5: Хүний нөөцийн хөгжлийг дэмжих, ажилтнуудын ёс зүйг сайжруулах, гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан цалин урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх						
5.1	Мэргэжлийн болон эрдмийн зэрэг цолтой эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтнуудыг тоог нэмэгдүүлэн, чадавхжуулах	-	Мэргэжлийн зэрэг, цолтой эмч, эрүүл мэндийн ажилтнуудын эзлэх хувь	2024 онд зөвлөх зэрэгтэй 6, ахлах зэргийн-36, тэргүүлэх-28 эмч сувилагч ажиллаж байна.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албаны дарга Д.Одончимэг сэтгэц судлалын эмчийн “Зөвлөх”, үзлэгийн эмч Э.Мөнх сэтгэц судлалын эмчийн “Тэргүүлэх”, үзлэгийн эмч Я.Ганхүү сэтгэц судлалын эмчийн “Ахлах” зэргийг, Сүрьеэгийн тасгийн сувилагч И.Уламбаяр, Ү клиникийн сувилагч Р.Энхтогос нар Сувилахуйн “Ахлах” зэрэг, туслах сувилагч хариуцсан ажилтан Д.Мөнгөнцэцэг сувилахуйн “Зөвлөх” зэргийг тус тус хамгаалсан байна.	100%
5.2	Эмч, сувилагч эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлагыг сайжруулж соён гэгээрүүлэх арга	-	Ёс зүйн зөрчлийн тоо	2024 онд Ёс зүйн зөрчлийн тоо -10	2025 оны 2 дугаар сарын 14-ний өдөр Төвийн сувилагч нарт “Стрессийг таньж ангижрах нь” зөөлөн ур чадварын сургалтыг зохион байгуулсан. 2025 оны 4 дүгээр сарын 16- ны өдөр, 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр тус тус 2 удаа “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудал” сэдвээр эмнэлгийн туслах сувилагч нарт сургалт зохион байгуулсан.	80%

	хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх				2025 оны 04 дүгээр сарын 21-ээс 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл Төвийн эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын сэтгэл оюуны чадамж, хамтын ажиллагаа бүтээлч байдал, асуудал шийдвэрлэх, цагийг удирдах, уян хатан байдал, харилцаа хандлагын ур чадварыг эрс сайжруулах, санал гомдлын тоог бууруулж, үйлчлүүлэгчдийн сэтгэлд хүрсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бодит хувь нэмэр оруулахад ёс зүйн хүрээнд эергээр үлгэрлэн, соён гэгээрүүлэх зорилгоор Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүний нөөцийн хөгжлийн алба, Ёс зүйн салбар хороо, “Зэлэм тархи” төрийн бус байгууллагатай хамтран Ерөнхийлөгчийн тамгын газар болон Эрүүл мэндийн яамны хөтөлбөрийн дагуу “Зөөлөн ур чадвар”-ын урт хугацааны цогц сургалтын хөтөлбөрийг батлуулж, Эрүүл мэндийн байгууллагуудын албадын дарга, эмч, сувилагч, мэргэжилтэн зэрэг 9 сургагч багш 7 хоног бүр ээлжлэн сургалтыг амжилттай, үр дүнтэй хүртээмжтэйгээр заан чиглүүлсэн ба төвийн ажилчдын 70 хувь хамрагдсан. Мөн “Орчин үеийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага” сэдэвт 2 багц цагийн сургалтыг зохион байгуулан нийт 38 эмч, сувилагч хамрагдсан. 2025 оны 5 дугаар сарын 12-ны өдөр “Олон Улсын сувилагчдын өдөр”-ийг угтан сувилахуйн албатай хамтран “Би сэтгэцийн сувилагч” сэдвийн хүрээнд “Эссэ” бичлэгийн тэмцээн зохион байгуулж, шилдэг ишлэлийг түүвэрлэн нийт сувилагч нартаа танилцуулсан. 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр Удирдлагын багтай хамтран 4 дүгээр клиникийн нийт эмч, сувилагч, туслах сувилагчдыг хамруулан “Клиникийн үйл ажиллагаанд багийн ажил нөлөөлөх нь” хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2025 оны 10 сарын 01-ны өдөр шинээр элссэн Резидент эмч нарт “Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ”, “Сэтгэцийн өвчтэй хүмүүсийн эрхийн асуудал” сэдэвт сургалт зохион байгуулсан. 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Амбулаторийн эмч,	
--	------------------------------	--	--	--	---	--

					ажилчдыг хамруулан “Эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ-хэцүү үйлчлүүлэгч” сэдвээр сургалт зохион байгуулсан. 2025 оны 11 дугаар сарын 05-ны өдөр 5 дугаар клиниктэй хамтран “Туслах сувилагчдын ажлын байрны аюулгүй байдал ба ёс зүйн хэм хэмжээ” сэдвээр шинээр ажилд орсон туслах сувилагч нарт зориулан чанарын өдөрлөг зохион байгуулсан.	
5.3	Эрүүл мэндийн ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлэх	-	Батлагдсан хөтөлбөр, хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	2022 онд хөтөлбөр батлагдсан.	Төвийн захирлын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/287 тоот тушаалаар “Хүний нөөцийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сэлгэн ажиллуулах журам”-ыг шинээр баталсан. 2025 оны хувьд ажилчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд: Ажилтны нийгмийн баталгааг сайжруулах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр 27 ажилтанд 7,850,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгосон. Өндөр настны тэтгэврээ тогтоолгосон 5 ажилтанд эрүүл мэндийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтын дагуу 140,212,039 төгрөгийн тэтгэмж олгосон. Төрийн дээд одон медаль, Салбарын шагналаар шагнагдсан ажилтны дагалдах мөнгөн шагнал болон нийгмийн баталгааг сайжруулах, урамшууллын зардалд 157,957,325 төгрөг тус тус зарцуулсан. Эмч, эрүүл мэндийн ажилтны мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр Бүгд Найрамдах Турк Улсад хүүхдийн Аутизмын оношилгооны “ADOS-2” хөтөлбөрийн дадлагажуулах сургалтад клиникийн эрхлэгч эмч Л.Цэрэндолгор, үзлэгийн эмч Б.Азбаяр, Х.Цэндсүрэн, Сэтгэц, нийгмийн эрүүл мэндийн албаны ахлах мэргэжилтэн, Е.Гүлжанат, амбулаторийн үзлэгийн эмч, Ш.Сугармаа нарт нийт 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Эрүүл мэндийн чанар, аюулгүй байдлын албаны дарга Д.Одончимэгийн Бүгд Найрамдах Солонгос улсад болсон олон улсын хуралд оролцоход 1,291,500 төгрөгийн дэмжлэг	100%

					үзүүлсэн. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цахимжуулах шийдлийг гаргах, урт хугацааны тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн даатгал зохицуулалтын албаны ахлах эмч, Л.Уянгыг Тайвань улс уруу сургалтад оролцох зардалд 2,500,000 төгрөгийг зохих журмаар зарцуулсан. Сэтгэцийн эмгэг судлалын нэгдүгээр клиникийн туслах сувилагч Э.Мөнх-Эрдэнэ, Донтох эмгэг судлалын клиникийн туслах сувилагч Ш.Одгэрэл нарт тус бүр 9,070,000 төгрөгийн үнэ бүхий иж бүрэн Монгол гэр, Гал түймрийн улмаас орон гэргүй болсон Шүүх сэтгэцийн эмгэг судлалын клиникийн туслах сувилагч Д.Батхуягийн гэр бүлд 6,980,00 төгрөгийн үнэ бүхий бүрэн тавилгатай монгол гэрийг тусламж болгон өгсөн. Удирдлагын зөвлөл, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны хороотой байгуулсан хамтын гэрээний дагуу ажилтны нийгмийн баталгаа сайжруулах чиглэлээр унааны мөнгийг 3000, хоолны мөнгийг 12,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн; Цэвэрлэгээ үйлчилгээ хийдэг туслах сувилагч болон үйлчлэгч нарт цэвэрлэгээ үйлчилгээний нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 0,5 хувиар бодож сар бүр олгодог болсон Ажилтны ажиллах тав тухтай орчин бүрдүүлэх зорилгоор клиник, тасаг, хэсгүүдэд 363,994,503 төгрөгийн урсгал засвар хийгдсэн. Ахмадууддаа хүндэтгэл үзүүлэн “Ахмадын баярын өдөр”-ийг тохиолдуулан 250 ахмад ажилтнаа хүлээн авч дурсгалын зүйл гардуулах үйл ажиллагаанд 20,142,000 төгрөгийг зарцуулсан, Эрүүл мэндийн болон бусад шалтгааны улмаас ажлын байраа солих хүсэлт гаргасан 2 ажилтныг хүсэлтийнх нь дагуу ажлын байрыг сольж ажиллуулсан. Төрийн дээд одон медаль-2, Эрүүлийг хамгаалах тэргүүний	
--	--	--	--	--	---	--

					ажилтан цол тэмдгээр-56, Эрүүл мэндийн яамны “Жуух бичиг”-21, Монголын эмч мэргэжилтэн, ажилтны үйлдвэрчний эвлэлийн хорооны “Мөнгөн чагнуур”-1 ажилтан тус тус шагнуулж 2,317,500 төгрөгийг шагналд дагалдуулан өгсөн байна. Цалинтай чөлөөг 30 ажилтанд, цалингүй чөлөөг 14 ажилтанд олгосон. Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны эмнэлгийн хуудас авсан ажилтан 124 /давхардсан тоогоор/ -д ажил олгогчоос 45,223,552 төгрөг олгосон. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардалд 749,764,703 төгрөг зарцуулсан. Үүнд: - Ажлын хувцас хамгаалах хэрэгсэлд -138,573,500 төгрөг, - Хор саармагжуулах бүтээгдэхүүнд -184,137,000 төгрөг, - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад 6,000,000 төгрөг, - Гал унтраах хэрэгсэлд -4,406,800 төгрөг, - Багаж тоног төхөөрөмжийн сайжруулан шинэчлэх зардалд -77,013,400 төгрөг, - Ажлын байрны тавилга солиход-53,652,900 төгрөг, - Ажлын байрны нөхцөл сайжруулах тохижилт үйлчилгээнд -363,994,503 төгрөг тус тус зарцуулсан.	
ЗОРИЛТ 6: Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах						
6.1	2025 оны тусламж, үйлчилгээний хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцоолон, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулан ажиллах	-	Төлөвлөсөн эмнэлгийн тусламж, үйлчилгээ, гүйцэтгэл	2024 онд ЭМДЕГ-тай гэрээ байгуулан, 14.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай УБ-01/017-0016 тоот, УБ-01/017-0064 дугаартай "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах, гэрээнд өөрчлөлт оруулах тухай нэмэлт гэрээ"-г тус тус байгуулсан. 2025 оны 1-ээс 4 дүгээр улиралд нийт 13,843,064,941 төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан. Үүнээс тус төвийн дансанд үндсэн гүйцэтгэлээс хасагдаж 11,667,254,599 төгрөг шилжин ирсэнг зохих журмын дагуу зарцуулсан.	90%
6.2	Санхүүгийн программыг	-	Хийгдсэн ажил,	2025 онд Санхүүгийн	Санхүүгийн программыг шинэчлэх, хөгжүүлэлт хийх зорилгоор 2025 онд 9,460,000 төгрөгийн гэрээ байгуулж	100%

	шинэчлэх, хөгжүүлэлтийг сайжруулж ажиллахдаа холбоотой зардлуудыг шийдвэрлэж ажиллах		зарцуулсан төсөв	программын хөгжүүлэлттэй холбоотой урсгал зардлыг тооцоолох	онлайн Fiscus программ нэвтрүүлэн ашиглаж байна.	
6.3	Уурын зуухны дулааны халуун усны БЗИУ 100-н тогоо, хэрэглээний халуун усны 27-н тогоо засварлах, ялтсан бойлер шинээр угсрах, бохирын шугамыг төвийн шугамд холбуулах, барилга хоорондын сантехникийн шугамын засварын ажил хийх	-	Хийгдсэн ажил, зарцуулсан төсөв	2024 онд Хийгдээгүй	Барилга хоорондын сантехникийн шугамын засварын ажил хийгдээгүй. Уурын зуухны “БЗИУ-100” маркын тогоо 1 иж бүрэн, ЭХЗУХ –ШТ-1000 тогоо 1 иж бүрдэл, хэрэглээний халуун усны болон дулааны шугам хоолойн гэмтэлтэй тоноглол хэрэгслэлүүдийг сольж шинэчлэн засварлаж, дулааны эрчим хүчээр тасралтгүй хангах нөхцлийг бүрдүүлсэн. Дээрх ажилд 19,230,000 төгрөг зарцуулан 30квт насос 2 иж, 1 квт, 2 квт сэнс 3 ширхэг, бусад шаардлагатай хэрэгслүүдийг шинээр тавьж урсгал засвар хийсэн.	70%
6.4	Мэдээллийн аюулгүй байдлын зөвлөмжийн дагуу дотоод үйл ажиллагааны сүлжээ, хяналтын камер зэргийг мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг хангаж сайжруулах	-	Тайлангийн тоо	А Г блокт сүлжээний шинэчлэлт хийгдсэн Б блок камер нэмэлтээр байршуулсан байгаа	Интернэт үйлчилгээ үзүүлэгч Юнивишн ХХК-ны гурвалсан үйлчилгээг байгууллагын интернэтээр сонгон хэрэглэж байна. Гэрээний хүрээнд байгууллагын гадаад, дотоод сүлжээнд өндөр хүчин чадал бүхий замлагч, галт хана төхөөрөмж “WatchGuard m290” суурилуулж, дотоод сүлжээний хаяглалыг шинээр зохион байгуулж хаяг давхцаж сүлжээ унах байдлыг таслан зогсоон, өндөр хүчин чадал бүхий төхөөрөмжөөр сүлжээний давтамж, найдвартай байдлыг хангасан. Цаашлаад галт хана төхөөрөмжийн “дашбоард”-ын тусламжтай дотоод сүлжээг бүрэн хянах бөгөөд мэдээллийн	100%

					аюулгүй байдлын 24/7 хяналтыг isp компани болох Univision хязгаарлагдмал хариуцлагтай компанийн гурвалсан үйлчилгээнд нэвтрүүлсэн. Нийт 98 ширхэг хяналтын камерын системийг 2,3,4,5,6 клиникт байршуулж, эмчлүүлэгчийн өрөөний аюулгүй байдлыг сувилагчийн постноос хянах боломжийг хангаж өгсөн. Мөн сүлжээний аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдын дотоод сүлжээний хаягжилтаас тусгаарлан зохион байгууллаа.	
6.5	Серверийн өрөөг стандартад нийцүүлэн шинэчлэн сайжруулах	30.0	Тайлангийн тоо	Тоног төхөөрөмж муу, тохижилтгүй	Серверий өрөөний стандарт зөрчигдөн аюулгүй байдал алдагдсан таазны хэсэг нурах, халааллын шугам гэмтэхэд учирч болох эрсдлийг арилгах үүднээс серверийн өрөөг нүүлгэн шилжүүлж стандарт зориулалтын шал, хаалаалтын шугам сүлжээний эрсдэлгүй болгож ажиллаа.	100%
ЗОРИЛТ 7: Гамшгийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллах, шинэ болон сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх						
7.1	Гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөнд тодотгол хийж шинэчлэн баталж хэрэгжүүлэх	-	Шинэчлэн батлагдсан төлөвлөгөө Нөөцийн бэлэн байдал	2024 онд Гамшгийн нөхцөл байдалтай холбоотойгоор 1-3 сарын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн ажилласан.	Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулж гамшгийн үед сэтгэцийн эрүүл мэндийн хамгаалах дэмжих чиглэлээр төлөвлөгөө боловсруулж ажиллаж байна. Тайлангийн хугацаанд 1-ээс 3 сарын баталгаат нөөцийг бүрдүүлэн, зарцуулалтад хяналт тавин ажилласан.	90%
7.2	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зуд гамшгийн үед сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх чадавхжуулах сургалт зохион	50.0 (Үйл ажиллагааны орлого)	Сургалтад хамрагдсан хүний тоо	2024 онд бүсчлэн зохион байгуулагдсан.	Гамшгийн үед нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сайн дурын ажилтан бэлтгэх олон улсын сургагч багш бэлтгэх сургалтад П.Энх-Учрал хамрагдаж Үндэсний сургагч багш болон сайн дурын ажилтан бэлтгэхэд ашиглах гарын авлагыг Монголын Улаан Загалмайн Нийгэмлэгтэй хамтран боловсруулсан. Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг, Японы Улсын Улаан Загалмайн Нийгэмлэгтэй хамтарсан "Үндэсний	100%

	байгуулах				сургагч багш” бэлтгэх сургалтад Л.Мөнхтуяа, Л.Эрдэнэсүвд нар 2025 оны 4 дүгээр сарын 22-ноос 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрүүдэд хамрагдсан. “Эрүүл Монгол Хүн” үндэсний хөтөлбөрийн санхүүжилтээр “Тогтвортой санхүүжилт” ХХК-тай хамтран дэлхийн 45 оронд хэрэгждэг Mental Health First Aid /MHFA/ буюу Сэтгэлзүйн эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх олон улсын хөтөлбөрийн сургагч багш бэлдэх эхний сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрүүдэд хамтран зохион байгуулсан бөгөөд сургалтанд хувийн хэвшлийн болон мэргэжлийн байгууллагын төлөөлөл болон олон нийтийн төлөөлөлөөс бүрдсэн 35 хүн хамрагдсан.	
7.3	Галын аюулгүй байдлын сургалтыг Баянзүрх дүүргийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулах.	-	Сургалтын тайлан, хамрагдсан ажилтны тоо	2024 онд сургалт хийгдсэн.	Ажилтан бүрд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн мэдлэгийг олгож, аюулгүй ажиллах соёлыг эзэмшүүлэх зорилгоор “Ололт-амжилтын түлхүүр” сургалтын төвтэй хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг 2025 оны 6 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад 250 ажилтан хамрагдсан бөгөөд сургалтыг Олон улсын стандартын тэргүүлэх аудитор, сургагч багш Б.Батхүү, дотоод стандартын аудитор, гамшгийн үнэлгээний мэргэжилтэн, сургагч багш Г.Итгэл болон хүний нөөц, хөгжлийн албаны мэргэжилтэн М.Даваадулам нар удирдан явуулсан. Мөн эрсдэлтэй ажлын байр, даралтат савны сургалтад 18 ажилтанг хамруулж, 4 ажилтан эрхийн үнэмлэх авсан. 2025 оны 6 дугаар сард нийт 677 ажилтанд 6 удаагийн давтамжтай Галын аюулгүй байдал, онцгой байдлын үед авах арга хэмжээ, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого сэдэвт сургалт зохион байгуулсан. Уг сургалтад хамрагдсанаар ажилтнууд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн мэдлэгээ бэхжүүлж, үйлдвэрлэлийн осол буюу ажлын байран дахь аюулыг илрүүлэх, мэдээлэх, урьдчилан сэргийлэх ойлголтоо нэмэгдүүлснээс гадна галын аюулгүй байдал,	100%

					онцгой байдлын үед хариу арга хэмжээг хэрхэн авах талаар онолын мэдлэгээ бататгасан.	
ХЭРЭГЖИЛТИЙН НИЙТ ХУВЬ						87.3%

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ



Н.УРАНТҮЛХҮҮР